



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/909

Ховд

Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн
төлбөрийг зарцуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөр төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж буй иргэдээс 2019 онд төвлөрсөн 60.946.516 /жаран сая есөн зуун дөчин зургаан мянга таван зуун арван зургаан/ төгрөгний 50 хувь болох 30.473.258 /гучин сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун тавин найман/ төгрөгийг Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний дагуу Сангийн яамны Төв төрийн сангийн 100900000704 тоот дансанд шилжүүлэхийг Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д зөвшөөрсүгэй .

2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн мөнгөн төлбөрийн орлогын 50 хувь болох 30.473.258 /гучин сая дөрвөн зуун далан гурван мянга хоёр зуун тавин найман/ төгрөгийг орон нутгийн төрийн сангийн тусгай дансанд төвлөрүүлэн байршуулж, Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт сурталчилах, хэрэгжилтийг хангах, цэргийн штабын үндсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр зарцуулахыг Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д даалгасугай.

3. Орон нутгийн тусгай дансанд төвлөрсөн мөнгөн төлбөрийн зарцуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай


4. Орон нутгийн тусгай дансанд төвлөрсөн мөнгөн төлбөрийг захиран зарцуулсан тайлангаа цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан ажлын гүйцэтгэлийн хамт тусгай маягтын дагуу гаргаж, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэн тооцоо хийж, ажлын үр дүнг танилцуулахыг Цэргийн штабын дарга /хурандаа Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай .

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 24-ний өдрийн
А/909 дүгээр захирамжийн хавсралт



ОРОН НУТАГТ ҮЛДЭХ САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨСӨВ

№	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын хавсралтын холбогдох заалт	Зохион байгуулах арга хэмжээний болон худалдан авах бүтээгдэхүүн үйлчилгээний нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /төгрөгөөр/	Мөнгөн төлбөрийн орлогоос зарцуулах хувь	Тайлбар
1	4.1.1. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;	"Соёмбо" сонин, "Цэргийн шинэчлэл" сэтгүүл захиалах үнэ	80	6500	520000	1.7	
		"Халхын голын байлдааны ялалтын 80 жил"-ийн ойд зориулсан ТВ хэлэлцүүлэг, сонины нийтлэлийн төлбөр	1	500000	500000	1.6	
		Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд сонины зохиомж нийтлэлийн үнэ	1	48000	48000	0.2	
		"Дуунд мөнхөрсөн баатрууд" номны төлбөр	10	15000	150000	0.5	
		Цэргийн албаны тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд хэвлэсэн тараах тараав материалын фото цаас болон өнгөт хорны үнэ	1	166000	166000	0.5	
		Зэвсэг хүчний 98 жилийн ой "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэнх арга	1	2900000	2900000	9.5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 03

	хэмжээний шагнал урамшуулал					дугаар сарын 07-ны өдрийн А/144 тоот захирам жаар зарцуулсан
	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүний Улаанбаатар хотод "Үэлээвэр найрал хөгжмийн улсын уралдаан"- д оролцоход дэмжлэг үзүүлэх	1	500000	500000	1.6	АЗД-ын 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/316 дугаар захирам- жаар зарцуулсан
	МУЗГ-ын 2017 оны 144 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/165 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, тайван цагт эрүүл мэндээр тэнцдэггүй иргэдийг Цэргийн төв эмнэлгийн эмч нарын үзлэгт хамруулж цэргийн цүртгэлээс хасах шийдвэр гаргах, холбогдох албан тушаалтнуудтай сургалт явуулахад шаардагдах зардал	1	1646000	1646000	5.4	Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/368 дугаар захирам жаар зарцуулсан
	Батлан хамгаалахын сайд Ховд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хавсралтын 1.3-д заасны дагуу баруун бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын	1	3466940	3466940	11.4	Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 14- ний өдрийн А/371 дүгээр захирам- жаар зарцуулсан

	газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл сургалт"-д оролцоход шаардагдах зардал					
	Батлан хамгаалахын сайд Ховд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хавсралтын 2.4-д заасны дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийн "Цэргийн дүйцүүлэх албаны болон тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалтыг явуулахад шаардагдах зардал	1	5612940	5612940	18.4	Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/685 дугаар захирам жаар зарцуулсан
	Батлан хамгаалахын сайд Ховд аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хавсралтын 5.1-д заасны дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 болон 332 дугаар салбаруудын сургалтын орчинг дээшлүүлэх зардал	2	1500000	3000000	9.8	
	Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, хүүхэд залууст цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх ажлын самбар хэвлүүлэх зардал	7	55000	385000	1.3	

	4.1.2. орон нутгийн хамгаалалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийг зохион байгуулах зардалд	1	4000000	4000000	13.1	
2	4.1.4. Цэргийн штабын бэлэн байдал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах;	Цэргийн штабын "Цэргийн бүртгэлийн программ"-ыг ажиллуулахад шаардагдах DELL I3 nootbook	1	1299900	1299900	4.3	
		Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах зөөврийн хард диск	1	180000	180000	0.6	
		Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах зөөврийн флаш диск	4	20000	80000	0.3	
		Компьютерийн MOUSE	2	14900	29800	0.1	
		Мэдээлэл аюулгүй байдлыг хангах архив, нууцын өрөөний цонхыг нууцын шаардлагад нийцүүлэн торлох зардал	1	174750	174750	0.6	
3	4.1.6. аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Аймгийн Батлан хамгаалах газрын болон Цэргийн штабын бэлэн байдлыг дээшлүүлэх хээрийн командын байр дэлгэхэд зориулж асар /майхан/ худалдан авах болон УБ хотоос авчрах тээврийн зардалд	1	2300000	2300000	7.5	
4	4.1.8. Цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;	Цэргийн штабын тоо бүртгэлийн болон дайчилгааны офицеруудын албанд өрөөний ажиллах орчин нөхцлийг	1	70000	70000	0.2	

		сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр цайны хэрэгслийн үнэ					
		Цэргийн штабын офицеруудын ажиллах нөхцөлийг сайжруулж бичгийн хэрэгсэл, төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд	1	785000	785000	2.6	
		Цэргийн штабын албан хэрэгцээний 30-50ХОУ улсын дугаартай Landcruiser 80 маркын машины аккумулятор худалдан авахад	1	400000	400000	1.3	
5	4.1.10. цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа ны хувцас хэрэглэлээр хангах.	Жаргалант сумаас 2019-2021 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан зорилтот бүлгийн иргэний цэргийн дүрэмт хувцасны зардалд	1	178000	178000	0.6	"Бөртэ" ТӨААТҮГ-ын нэхэмжлэх №140
		Бүгд дүн:			28392330	93,1	